

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

**ОРХОН АЙМГИЙН ЗДТГ-ЫН НБХ-ИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН О.БАТЦЭНГЭЛИЙН
2024 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|--|--|---------------------------|---------------------|-----------------|--|--------------------------|--------------------------------|---------------------|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | 5 | | |
| 1 | 2 | 3 | 4 | | | 6 | 7 | |
| Зорилт 1. "Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ | | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Зонхиолнон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг /хөх, умай, чихрийн шижин, цусны дараалт ихсэх/ үзлэгийг эрчимжүүлэх | Эрт илрүүлгийн хувь | 40,5% | 42% | Tайлант хугацаанд халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хамралт 80,1% болж өмнөх оны мөн үеэс 15,3 %-аар нэмэгдсэн байна. Үүнд: Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 18-с дээш насын нийт 43285 буюу хамрагдвал зохих хүн амын 85.4 хувийг эзэлж, өмнөх оноос (6.8) хувиар өсч үр дүнгийн үзүүлэлтээр 0.7 хувь нь онош батлагдсан. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 18-дээш насын нийт 39328 буюу хамрагдвал зохих хүн амын 77.6 хувийг эзэлж, өмнөх оноос (22.7) хувиар буурч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.3 хувь онош батлагдсан байна. Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насын нийт 3354 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насын эмэгтэйчүүдийн 84.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (11.4) хувиар буурсан. Пап шинжилгээнд нийт 1645 сорьц хүлээн авсан байна. Хөхний эрт илрүүлэг үзлэгт 17285 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насын эмэгтэйчүүдийн 83.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (4.5) хувиар өссөн байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 1214 хүн буюу (69.5) хувь нь хамрагдсан. | 2024.01.01 2024.12.31 | 100% | |

| | | | | | | | | |
|----|--|--|--|----|---|--|--------------------------|------|
| | | | | | Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, өвчлөлөөс сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн сургагч багш бэлтгэх сургалтад 140 идэвхтэн иргэд, сурагчдыг хамруулан, СӨБ, ЕБС, эрүүл мэндийн салбарын 170 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Иргэдэд эрүүл мэндийн боловсролыг олгохоор 11 төрлийн постер, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 168531 иргэнд хүргэж, 6 удаагийн өдөрлөг зохион байгуулж 14468 хүний хамруулж ажилласан. Аймгийн хэмжээнд эрт илрүүлэг 60%-тай байна | | | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих "Эрүүл хамт олон" хөдөлгөөн өрнүүлж, сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулах | Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо | | 81 | 83 | Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих "Эрүүл хамт олон" хөдөлгөөн өрнүүлж, "Энэ жилдээ Эрүүл жиндээ-2", "Хичээллэ-Өрнүүлье-Хөгжүүлье" аяны хүрээнд Биеийн тамир спортын газартай хамтран "Ажлын байрны дасгал хөдөлгөөн" 2 сарын цахим уралдааныг зохион байгуулж 33 байгууллагын давхардсан тоогоор 7384 ажилтан албан хаагчдыг хамруулсан. Эрдэнэт үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн албатай хамтран 33 цех дарга, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан 66 хүнд "Эрүүл мэндийн дэмжигч" байгууллага хөдөлгөөний талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аян хүрээнд Орхон аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран харьяа 16 байгууллагын 800 албан хаагчдын дунд "Шүд угаах цаг" аяныг өрнүүлж цайны цагийн дараа шүд угааж хэвшсэн байгууллагыг шалгаруулж олон нийтэд алдаршуулж ажилласан. Тайлант хугацаанд ажлын байранд эрүүл мэндийг дэмжих зорилгоор орон нутгийн төсвөөс 6,0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгувалсан. 2024 онд Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох хүсэлт ирүүлсэн 9 байгууллага, зэрэглэл ахиулахаар 7 байгууллага ирүүлж, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/472 дугаар тушаал Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын хэсэг ажлын байранд дээр очиж үнэлгээ хийж, сонгон шалгарууллаа. Аймгийн | 2024.01.01 2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|----|---|---|-----|-------|---|--------------------------|------|
| | | | | | хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 90-тай боллоо | | |
| 3. | Арга хэмжээ 1.3. Хорт хавдартай иргэдийн эмийн болон эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх | Дэмжлэгт хамрагдсан хорт хавдартай иргэдийн тоо | 150 | 162 | Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 130.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээс 2024 онд аймгийн Засаг даргын 2024 оны А/236, А/446, А/634 дүгээр захирамжаар нийт 205 иргэнд 130,0 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон. Тайлант хугацаанд хавдрын шинээр батлагдсан тохиолдлын 83,5 хувь нь эмийн болон эмчилгээний дэмжлэгт дэмжлэгт хамрагдсан байна | 2024.01.01 2024.12.31 | 100% |
| 4 | Арга хэмжээ 1.4. Эрүүл мэндийн ажилтны сургалт, нийгмийн асуудлыг дэмжих “Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 96% | 96,8% | <p>Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын 2024 оны А/86-р захирамжаар “Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 130.0 сая төгрөг, аймгийн ИТХ-ын 2024 оны 18/05 тогтоолоор 20.0 сая төгрөг нэмэлтээр тус тус батлагдсан. Хөтөлбөрийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Бид дорнын анагаах ухааны их эмч”, “Миний мэргэжил-Миний бахархал-Би эмч”, “Миний мэргэжил-Миний бахархал-Би сувилагч” сэдвээр ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулж 104 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. - Эрүүл мэндийн байгууллагуудын 6 эмнэлгийн мэргэжилтэн БНСҮ, 8 өрхийн эрүүл мэндийн төвийн дарга ӨМӨЗО-ны Хөх хотын эрүүл мэндийн байгууллагаас туршлага судалсан. - 11 удаагийн сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнд давхардсан тоогоор 1530 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. - Дэлхийн эмч нарын болон олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан онол практикийн бага хуралд 106 судлаач оролцсон. - Эрдэнэт хотын “Илгээлтийн эзэд” эрүүл мэндийн салбарын 100 ахмадын уулзалтыг зохион байгуулсан. - Эрүүл мэндийн салбарын 36 ажилтанд 36,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. - Эрүүл мэндийн байгууллагуудын 70 ажилтныг умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг, 24 ажилтныг бүдүүн гэдэсний дуранд хамруулсан. | 2024.01.01 2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|--|-----|-----|---|--------------------------|------|
| | | | | | Tайлант хугацаанд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 14 байгаа нь өмнөх оноос 0,9%-аар нэмэгдсэн ба нийгмийн дэмжлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтны эзлэх хувь 27.8% болж өнгөрсөн оны мөн үеэс 3.4%-аар өссөн. Эмч хөтөлбөрийн хэрэгжилт: 2021 онд 90%, 2022 онд 96,9%, 2023 онд 98,8%, 2024 онд 98.7% буюу 4 жилийн хөтөлбөрийн дундаж 96%-тай хэрэгжүүлэн ажиллалаа: | | |
| 5 | Арга хэмжээ 1.5. Иргэдийн дунд авлагагүй донорын эгнээг өргөжүүлж, аюулгүй цус цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэх | Цус цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн нөөцийг нэмэгдүүлэх хувь | 96% | 97% | <p>Аймгийн Засаг даргын 2024 оны А/229 дугаар захирамжаар 8,0 сая төгрөгийг шийдвэрлэж, “Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ бэлэглэ” уриан дор сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, цусны аюулгүй байдлыг хангах, доноор хадгалах идэвх санаачилгыг өрнүүлэх аяныг зохион байгуулсан.</p> <p>Суурин цус цуглувалтаар 562 доноороос 562 нэгж цус, шинэ 140 доноороос 140 нэгж цус цуглувалсан. Цусны салбар төвд бүртгэлтэй 562 доноорт цусны АВО, Резус бүлэг, Келл бүлэг, цус, цусан бүтээгдэхүүнээр дамжих халдварт илрүүлэх шинжилгээг хийж 100% баталгаажуулсан ба резус зерэг 560, серөг 2 доноор бүртгэгдсэн. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх тусламж үйлчилгээний бэлэн байдлыг үнэлэх чиглэлээр 67 эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулсан.</p> <p>Тайлант хугацаанд 1152 нэгж цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэснээс 908 нэгж цус цусан бүтээгдэхүүнийг зарцуулсан байна. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэлтэй холбоотой урвал хүндэрэл 2 бүртгэгдсэн. Тайлант хугацаанд цус цусан бүтээгдэхүүний хангалт 100%-тай байна.</p> | 2024.01.01 2024.12.31 | 100% |
| 6 | Арга хэмжээ 1.6. Суурь өвчтэй хүүхдүүдийг улирлын чанартай гэр сувилалд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх | Суурь өвчтэй хүүхдийн эрүүлжсэн хувь | 86% | 88% | Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувилыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг шийдвэрлэснээр Бүжинлхам хувийн хэвшлийн хүүхдийн клиник сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 100 хүүхдийг нар ус агаараар чийрэгжүүлэх зуны сувилалд хамруулсан. Гэрээний хэрэгжилт 98% байна | 2024.01.01 2024.12.31 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|-------|-----|--|--------------------------|------|--|
| 7 | Арга хэмжээ 1.7. Нийгмийн халамж нэн шаардлагатай жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг аминдэмд хамруулах | Аминдэмжүүл элтийн хангалтын хувь | 15% | 17% | Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2024 оны А/472 дугаар захирамжаар батлагдсан 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн эмчилгээний зорилгоор 243, урьдчилан сэргийлэх тунгаар 644, нийт 887 жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмжүүлсэн. Аминдэмжүүлэлтэд хамрагдсан нийт 887 эхээс 243 буюу 27,4 хувь нь цус багадалтай эх байгаа ба эх барихын хүндрэлгүй төрүүлсэн. Тайлант хугацаанд аминдэмд хамрагдах эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 1.2 дахин нэмэгдсэн буюу жирэмсэн, хөхүүл эхчүүдийн 33,3%-ийг хамруулсан байна | 2024.01.01 2024.12.31 | 100% | |
| Зорилт 2. “ Эмнэлгийн тусlamж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, орчин үеийн оношилгоо эмчилгээний дэвшилтээ технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна ” | | | | | | | | |
| 8 | Арга хэмжээ 2.1. Өрхийн эрүүл мэндийн төвтэй гүйцэтгэлийн гэрээ байгуулж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавьж, ЭМЯ-д хүргүүлэх | Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээг жилд 2 удаа дүгнэх, дундаж хувь | 88,3% | 89% | Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журмыг батлах тухай” А/122 тоот тушаалын дагуу өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний баг, журам, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн баталсан. Батлагдсан захирамжийг салбарын шуурхай болон өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, ахлагч наарт 2 удаа танилцуулж, мэдээлэл хийсэн. Гэрээний гүйцэтгэлийн хэрэгжилтийг жилд 2 удаа тухайн жилийн 7-р сарын дотор, дараа жилийн 1-р сарын дотор үнэлхэээр тусгагдсан бөгөөд тайлант хугацаанд эхний хагас жилийн хэрэгжилтийн үнэлгээ хийсэн. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гүйцэтгэлийн гэрээний дундаж 92,7% болж, өмнөх оны мөн үеэс 5,4%-аар нэмэгдсэн байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавьсан илтгэх хуудсыг ЭМЯ-д хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа. | 2024.01.01 2024.12.31 | 100% | |
| 9 | Арга хэмжээ 2.2. Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, тоног | Стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлсэн эрүүл | 88,9% | 91% | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр 276.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс орон нутгийн төсөв 163.7 сая (59,2%), төсөл хөтөлбөр 112.7 сая (40,8%) төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Үүнд: | 2024.01.01 2024.12.31 | 100% | |

| | | | | | | | | |
|----|---|------------------------|---|---|--|--|--------------------------|------|
| | төхөөрөмжийн хангалтыг сайжруулан стандарт чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлэх | мэндийн төвийн тоо | | | Oрон нутгийн 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 өрхийн эрүүл мэндийн төвийг мобайл технологиор, 17.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Анхны-Оч, Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төвийг нярайн шарлагын аппаратаар, 48.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Анхны-Оч өрхийн эрүүл мэндийн төвийг цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат, нярайн шарлагын аппаратаар, 9.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төвийг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр, Жаргалант сумын эрүүл мэндийн төвд 29.0 сая төгрөгийн шарлагын аппарат болон тавилга багаж хэрэгслээр тус тус хангасан Азийн Хөгжлийн банкны МОН-9218 төслийн хүрээнд 13.7 сая төгрөгийн өртөг бүхий 6 нэр төрлийн 54 ширхэг тоног төхөөрөмжийг сум, өрхийн дархлаажуулалтын 9 нэгжид, олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд нүдний улаан рефлекс шалгах Arclite багажийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 15 ширхгийг тус тус хуваарилсан. Мөн Дезерет олон улсын байгууллагаас Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 99,0 сая төгрөгийн нярайн шарлагын аппарат болон бусад техник хэрэгслээр хангасан. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 96% болж өмнөх оноос 0,4%-аар нэмэгдсэн байна. | | | |
| 10 | Арга хэмжээ 2.3. Алслагдсан гэр хороололын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд алсын болон зөөврийн Мобайл технологи нэвтрүүлэх | Мобайл технологийн тоо | | 1 | 4 | Oрон нутгийн 60 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 өрхийн эрүүл мэндийн төвийг мобайл технологиор хангагдсанаар 5 өрхийн эрүүл мэндийн төв буюу нийт өрхийн эрүүл мэндийн төвийн 62,5% нь мобайл технологиор хангагдсан. Тайлант хугацаанд мобайл технологиор гзрийн эргэлтийн IV, V-р бүлгийн эргэлт, алслагдсан багийн малчдын эргэлт, явуулын үзлэг, байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэг зэрэг ашиглаж давхардсан тоогоор 10,000 гаруй хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. | 2024.01.01 2024.12.31 | 100% |
| 11 | Арга хэмжээ 2.4. БОЭТ-ийн Мэс заслын нэгдсэн | Засвар хийгдсэн байна. | - | | Тайлант хугацаанд орон нутгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэс заслын нэгдсэн тасагт 533.3 сая төгрөг, Гэмтлийн тасгийн их засварт 305.2 сая төгрөг, эмчилгээний хоолны тасгийн | 2024.01.01 2024.12.31 | 100% | |

| | | | | | | | |
|---|---|--|-----|------|---|--------------------------|------|
| | тасаг, гэмтлийн тасгийн засварыг хийж, стандарт чанарын шаардлага хангасан эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэх | | | 100% | дээврийн засварт 44,0 сая төгрөгийн нийт 882.5 сая төгрөгийн их засварын ажлууд хийгдэж дууссан. | | |
| Зорилт 3. "Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах" | | | | | | | |
| 12 | Арга хэмжээ 3.1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааны ил тод байдлыг хангах | Хурлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 95% | 100% | <p>Тусгай зөвшөөрөл олгох комиссын 11 удаагийн хурлаар нийт 86 асуудлыг хэлэлцэж, сунгалт хийлгэх 39 байгууллагын материалыг хүлээн авч үйл ажиллагааг 5 жилээр сунгаж, 10 байгууллагыг түдгэлзүүлж, 5 байгууллагад хаягийн шилжилтийн зөвшөөрлийн олгосон. Шинээр нээх 6 төслийг хүлээн авч, 1 дотор, 1 сэргээн засах тусlamж үйлчилгээг үзүүлэх клиник нээгдсэн. 12 байгууллагын зөвшөөрлийг хүчингүй болгосон. Сунгалт хийлгэх байгууллагуудад салбарын хяналтын байцаагч нарын дүгнэлт, ажлын албанаас 8 удаа хяналтын дүгнэлтүүдийг тус тус комиссын хуралд оруулсан. Ажлын албанаас эрх зүйн баримт бичгийн шинэчлэлт, халдварт сэргийлэлт, эмийн чанар аюулгүй байдал, сувилахуйн чиглэлээр 45 клиникийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт зохион байгуулсан. Орон тооны бус 2 шинжээчийг шинээр нээх 5 төсөл болон 3 ажлын байранд ажиллуулж, үнэлгээг комиссын хуралд оруулж шийдвэрлүүлсэн. ЭМХТ-д тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, цахми програмын сургалтад хамрагдсан.</p> <p>Хууль эрх зүйн хэлтэст 2023 оны сунгасан, шинээр олгосон, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж хүргүүлсэн. Орон тооны бус шинжээчийн сонгон шалгаруулалтыг ЭМГ-ын цахим хуудас, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж 1 шинжээчийн материалыг хэлэлцүүлсэн. Ажлын албанаас түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон нийт</p> | 2024.01.01 2024.12.31 | 100% |

МХ

| | | | | | | | |
|----|---|--|-----|-----|--|--------------------------|------|
| | | | | | 17 байгууллагад тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага хангах албан бичгийг хүргүүлж, 1 эмийн сан, 1 клиникт ирүүлсэн иргэний 2 гомдлыг шийдвэрлэж ажилласан. ЭМГ-ын Or.mohs.gov.mn фэйж хуудсанд тусгай зөвшөөрөл гэсэн линкэд эрх зүйн баримт бичгүүд, сунгуулах болон шинээр авах байгууллагын бүрдүүлэх материалыг ил байршуулж, мэдээлэлийн ил тод байдлыг ханган ажиллалаа. License.mn сайтад нийт 163 байгууллагын мэдээлэл, туршилтаар сунгуулах 2 байгууллагын мэдээллийг 100% шивж оруулсан | | |
| 13 | Арга хэмжээ 3.2. Эмнэлгүүдийг магадлан итгэмжлэлд хамруулж, эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Батлагдсан хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт | 90% | 95% | <p>Сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв, хувийн хэвшлийн ортой 13 клиникт чанарын баг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсэн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг, Эрдэнэт сувилалд нийт чанарын 5 алба ажиллаж байна.</p> <p>- Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар хүртээмж, "Чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө"-ний хэрэгжилт, Эмчилгээ чанарын албад, багийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт 5 удаа, чадавхжуулах чиглэлээр сургалт мэдээлэл 6 удаа хийж, зөвлөмжөөр хангаж ажилласан.</p> <p>- Эмчилгээ чанарын алба, багийн төлөвлөгөөний хэрэгжилт дундажаар 93,1%-тай үнэлэгдсэн, чанарын албаны хурал 98, дотоод хяналт 114, ижил мэргэжилтний үзлэг 32 чиглэлээр 376 удаа хийж, тусlamж үйлчилгээтэй холбоотой 273 тохиолдол бүртгэн дотоодын 28 сургалт, 6 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, давхардсан тоогоор 424 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан байна. Эрүүл мэндийн байгууллагууд http://eburgtgel.moh.gov.mn цахим программд тусlamж үйлчилгээтэй холбоотой тохиолдлыг бүртгүүлж хэвшсэн. Тайлант хугацаанд бүртгэгдсэн тусlamж үйлчилгээтэй холбоотой 273 тохиолдлоос эмнэлзүйн шалтгаан 43,6%, эмнэлзүйн бус шалтгаан 46,2%, бусад 9,2% бүртгэгдэж, хариу арга хэмжээг 85,0%-д авч ажилласан байна. Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг эрүүл</p> | 2024.01.01 2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|--|----------------------|------|------|---|--------------------------|------|
| | | | | | | | |
| Зорилт 4. "Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах" | | | | | | | |
| 14 | Арга хэмжээ 4.1. TAX-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | TAX-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд гарган өгч ажиллалаа. | 2024.01.01 2024.12.31 | 100% |

4

| | | | | | | | |
|----|---|--|-----|----|--|--------------------------|------|
| | батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | | | 2024 онд 71 албан бичгийн хугацаанд нь шийдвэрлэн хааж, харьяа агентлагиудад чиглэл өгсөн 34 албан бичгийг хүргүүлэн ажилласан байна | | |
| 15 | Арга хэмжээ 4.2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх | Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо | 130 | 60 | Иргэдээс ирүүлсэн 245 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэв | 2024.01.01 2024.12.31 | 100% |

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/Д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|-----|--|---|--------------------------------|-----------------------------|--|--------------------------------|--------------------|
| 1. | Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллах, өгөгдсөн үүрэг | Комисс, ажлын хэсэгт ажилласан тоо | Шийдвэрийн дагуу ажиллах | Шийдвэрийн дагуу ажиллах | Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллаж, удирдлага болон ЗДТГ- ын албан хаагчдын хурлаас өгөгдсөн нийт 33 үүрэг даалгавар, хэлтсийн даргаас өгөгдсөн 12 үүрэг даалгаврын | 2024.01.01 2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|------------------------------|-------------------|--|--|---|--------------------------|------|
| | даалгаврыг шуурхай гүйцэтгэх | | | | биелэлт 99,1%-тай шуурхай шийдвэрлэн гүйцэтгэн ажиллалаа. | | |
| 2 | Шийдвэрлэсэн албан бичиг | Албан бичгийн тоо | Албан бичгийн шийдвэрлэж хариуг өгсөн байх | Албан бичгийн шийдвэрлэж хариуг өгсөн байх | Ирүүлсэн нийт 71 албан бичгийг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэв | 2024.01.01 2024.12.31 | 100% |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | | |
|--|---|--|---------------------|---|---|--------------------------|-----------------|------|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь | |
| | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1. Байгууллагын зүгээс зохион байгууласан сургалт үйл ажиллагаанд хамрагдах | Өөрийгөө хөгжүүлэх сургалтад хамрагдсан байна. | 4 | Ажил үүргийн холбогдолтой сургалт үйл ажиллагаанд хамрагдах | 1.“Хойд бүсийн хөгжлийн форум” 2.“Төрийн бүтээмжийн сэргэлт-эрүүл мэндийн салбарын цахим шилжилт” сургалт 3.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагдаж буй “7:4:10” сургалт 4.Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөө 5. “Дижитал хот”сэдэвт зөвлөгөө 6. Монгол улсын хөгжлийн бодлого- үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл сургалтад тус тус хамрагдлаа | 2024.01.01 2024.12.31 | | 100% |
| 2 | Арга хэмжээ 2. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай | -Сургалтуудад хамрагдсан байна. | 4 | Ажил үүргийн холбогдолтой сургалт үйл ажиллагаанд хамрагдах | 1.MNS 7014:2023 Эрүүл мэндийн үйлчилгээний стандартын сургалт 2.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс зохион байгуулагдах “Орчны эрүүл мэнд”-ийн цахим сургалт 3.“Зудын гамшигийн үеийн сэтгэцийн гүйцэтгэлийн дэмжлэг үзүүлэх” сэдэвт бүсийн сургалт | 2024.01.01 2024.12.31 | | 100% |

| | | | | | |
|--|--|--|--|--|--|
| | мэдлэг чадвараа дээшлүүлэх холбогдох хууль тогтоомжийг судлах, сургалтад хамрагдах | | | 4.“Нярайн скрининг оношилгоогоор төрөлхийн зарим эмгэгийг эрт илрүүлэх нь” сэдэвт сургалт 5.“Хойд бус нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах хөх кодоор ажиллах чадварт суралцах нь” сургалт 6.“Хүүхдэд зонхилон тохиолдох эмгэгийн үеийн менежмент” сургалт 7.“Дунд шатны Улаан Загалмайн хорооны дэргэдэх Гамшгийн хариу арга хэмжээ авах” бүсчилсэн сургалт 8.“Нялх, бага насын хүүхдийн хооллолтын зөвлөлгөө” орон нутгийн сургагч багш бэлтгэх сургалт 9.“Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах бэлэн байдлыг хангах нь” сэдэвт сургалт 10.“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, санал солилцох” цахим сургалт 11. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сургалт 12. ЭХМТ болон ЭХЭМҮТ-тэй хамтран “Стрептококкийн ангин, фарингит, Хэрэх өвчин, хэрэхийн шалтгаант зүрхний олдмол гажгийг эрт оношлох чадавх олгох” сургалтад тус тус хамрагдлаа | |
|--|--|--|--|--|--|

ТАЙЛАН ГАРГАСАН:

НБХ-ийн мэргэжилтэн
(Албан тушаал)

О.Батцэнгэл /...../
(Нэр, гарын үсэг)

2024.12.02.
(Огноо)